

  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/558

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 109 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202110075 дугаартай Хөхморьт сумын сургуулийн 2021 оны 4 дүгээр улиралд хэрэглэх нүүрс нийлүүлэх ажлыг “Өндөр Алтай тээвэрчид” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар (Б.Батбаатар)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар (Б.Батбаатар)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Наранбадрах), Санхүүгийн алба (Р.Алагаа), Сургуулийн захирал (Д.Наранцацралт)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ